



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2018 оны 04 сарын 24 өдөр

Дугаар 180

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө балансаас балансад
шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 30 дугаар зүйлийн 2, 31 дүгээр зүйлийн 1, 2, 3 дахь хэсэг, "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 5.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1."Эрдэнэт Булганы цахилгаан түгээх сүлжээ" төрийн өмчит хувьцаат компанийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 84,000,000.00 (наян дөрвөн сая) төгрөгийн балансын үнэ, 10,033,333.20 (арван сая гучин гурван мянга гурван зуун гучин гурван төгрөг хорин мөнгө) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан үндсэн хөрөнгийг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт балансаас балансад шилжүүлсүгэй.

2.Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын Захиргаа, хууль зүйн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Э.Эрдэнэхишиг, "Эрдэнэт Булганы цахилгаан түгээх сүлжээ" төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал Г.Баярцогт нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор үндсэн хөрөнгийг шилжүүлэх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.3.Энэ тогтоолын биелэлтийг 2018 оны 2 дугаар улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3.Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.

ДАРГА

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН ХЭЛТСИЙН
ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ




Ц.НЯМ-ОСОР

Э.ЭРДЭНЭХИШИГ

0001779

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2018 оны 04 дүгээр сарын 07-ны өдрийн
180 дугаар тогтоолын хавсралт



“Эрдэнэт Булганы цахилгаан түгээх сүлжээ” төрийн өмчит хувьцаат компаниас
Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт шилжүүлэх автомашин

Д/д	Хөрөнгийн нэр, Улсын дугаар, Арлын дугаар	Үйлдвэрлэсэн, ашиглалтад орсон он	Нийт гүйлт (км)	Балансын үнэ (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэх өртөг (төгрөг)
1	Форд транзит, тусгай зориулалтын /аяллын/ автомашин, 48-91 ОРХ улсын дугаар, WFOAXXGBVASK94499	1996/2015	188542	49,000,000.00	6,533,333.28	42,466,666.72
2	Авто чиргүүл, 4222 ГЧ улсын дугаар, SGDS99SWXO100710	1996/2015	-	35,000,000.00	3,499,999.92	31,500,000.08
Нийт дүн /тоогоор/				84,000,000.00	10,033,333.20	73,966,666.80
Нийт дүн /үсгээр/				(наян дөрвөн сая төгрөг)	(арван сая гучин гурван мянга гурван зуун гучин гурван төгрөг хорин мөнгө)	(далан гурван сая есөн зуун жаран зургаан мянга зургаан зуун жаран зургаан төгрөг наян мөнгө)